

**“Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг
тогтворжуулах (SIFS) дэд хөтөлбөр”-ийн зээлийн
шугамын **11** дэх ашиглалт гарлаа**

Монголбанкнаас жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнийг хамгийн бага зардлаар санхүүжүүлэхийн зэрэгцээ хил дээрх өртгийн ханшаас хамаарах нөлөөллийг бууруулж, жижиглэнгийн борлуулалтын үнийг тогтвортой байлгах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор SIFS дэд хөтөлбөрийг Уул уурхайн яамтай хамтран 2012.10.26-ны өдрөөс хэрэгжүүлж байгаа билээ.

Энэхүү дэд хөтөлбөрийн 11 дэх транчаар хөтөлбөрт оролцогч банкаар дамжуулан **“Шунхлай” ХХК**-д жилийн 3.8%-ийн хүүтэй, 1 жилийн хугацаатай **13.9** тэрбум төгрөгийн санхүүжилтийг 4 дүгээр сарын 19-ний өдөр шилжүүллээ.

Ийнхүү SIFS дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэгч **11** компани нь 2013.04.19-ны өдрийн байдлаар дэд хөтөлбөрийн дүнгийн **89.3%**-ийг буюу нийт **149.2** тэрбум төгрөгийн зээлийн шугамыг ашиглаад байна.

Дэд хөтөлбөрийн өмнөх ашиглалт болон хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Монголбанкны цахим хуудасны [“Үнийг тогтворжуулах хөтөлбөр”](#) цэснээс үзнэ үү.

--- оОо ---